

## ЦАХИМ МӨНГӨНИЙ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь заалт, 8 дугаар зүйлийн 2 дахь заалт, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 ба 3 дахь заалт, 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 1 дэх заалтын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт цахим мөнгө гаргах болон түүнтэй холбоотой үйл ажиллагааны зарчмуудыг тогтоох, цахим мөнгө гаргах зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, цахим мөнгө гаргагчид тавигдах шаардлагуудыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавихад оршино.
- 1.2. Цахим мөнгөний үйл ажиллагаанд Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, энэхүү журам болон Монголбанкнаас гаргасан бусад эрх зүйн актыг удирдлага болгоно.
- 1.3. Энэ журмаар Монгол Улсын нутаг дэвсгэрт цахим мөнгө гаргах, түүнийг тараах болон буцаан бэлэн мөнгөнд хөрвүүлэх, төлбөр, шилжүүлэгт хэрэглэх болон энэ үйл ажиллагааны оролцогчид тавих шалгуур үзүүлэлтийг зохицуулна.

### ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
  - 2.1.1. “Цахим мөнгө” гэж Үндэсний төлбөрийн систем (ҮТС)-ийн тухай хуулийн 5.1.25-д тодорхойлсон, 35 дугаар зүйлд заасан шинжийг агуулсан төлбөрийн хэрэгслийг;
  - 2.1.2. “Цахим мөнгөний үйлчилгээ” гэж бэлэн мөнгийг цахим хэлбэрт, цахим мөнгийг бэлэн мөнгөнд хөрвүүлэх, цахим мөнгөөр төлбөр гүйцэтгэх, гүйлгээ хийх ажиллагааг;
  - 2.1.3. “Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч” (цаашид үйлчилгээ эрхлэгч гэх) гэж Монголбанкнаас төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, цахим мөнгө гаргах зөвшөөрөл авсан хуулийн этгээдийг;
  - 2.1.4. “Цахим мөнгөний гэрээт төлөөлөгч” (цаашид гэрээт төлөөлөгч гэх) гэж үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр түүний нэрийн өмнөөс шинэ хэрэглэгчийн бүртгэл болон цахим мөнгөний үйлчилгээг гүйцэтгэх хуулийн этгээдийг;
  - 2.1.5. “Цахим мөнгө хүлээн авагч” (цаашид ЦМХА гэх) гэж үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр цахим мөнгийг төлбөрт хүлээн авч, өөрийн бараа, үйлчилгээг борлуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг;
  - 2.1.6. “Хэрэглэгч” гэж цахим мөнгөний үйлчилгээг авахаар үйлчилгээ эрхлэгчтэй гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;
  - 2.1.7. “Оролцогч” гэж гэрээт төлөөлөгч, ЦМХА, хэрэглэгчийг хамтад нь;

- 2.1.8. “Бодит цагийн горим” гэж гүйлгээг цаг тухайд нь хүлээн авах буюу дамжуулах горимыг;
- 2.1.9. “Гүйлгээ” гэж ҮТС-ийн тухай хуулийн 5.1.18-д заасан шилжүүлэгийг цахим мөнгө ашиглан гүйцэтгэх болон цахим мөнгөний системд хийгдэх бусад санхүүгийн бус үйлдлийг;
- 2.1.10. “Гүйлгээний баталгаажуулалт” гэж хэрэглэгч тухайн төлбөр, гүйлгээг хүлээн зөвшөөрч, нууц үг оруулах болон бусад аргаар баталгаажуулахыг;
- 2.1.11. “Баталгааны данс” гэж үйлчилгээ эрхлэгч нь банк бол Монголбанкинд, банкнаас бусад хуулийн этгээд бол банкинд байршуулсан, өөрийн гаргасан цахим мөнгөний мөнгөн хөрөнгийн баталгааг байршуулах дансыг;
- 2.1.12. “Цахим мөнгөний систем” (цаашид систем гэх) гэж үйлчилгээ эрхлэгч болон цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэхэд ашиглаж байгаа програм хангамж, техник тоног төхөөрөмж, түүний оролцогчид, холбогдох бодлого, журам, заавар, гэрээний нэгдсэн цогцыг;
- 2.1.13. “Нууц үг” гэж цахим мөнгөний үйлдлийг баталгаажуулахад ашиглагдах, зөвхөн тухайн оролцогч мэдэж байх тоо, үсгийн цувааг;
- 2.1.14. “Хулгайн гүйлгээ” гэж бусдын дансанд байгаа мөнгөн хөрөнгийг эзэмших, захиран зарцуулах эрхгүй этгээд санаатайгаар, нууцаар өөрийн эзэмшилд оруулах үйлдлийг.

## ГУРАВ. ЦАХИМ МӨНГӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ

- 3.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр цахим мөнгөний төлбөр тооцоог зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэнэ.
- 3.2. Цахим мөнгөний үйлчилгээ нь бусдаас ялгарах өөрийн гэсэн оноосон нэртэй байна.
- 3.3. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн дүрмийн сангийн доод хэмжээ нь 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөг байна.
- 3.4. Цахим мөнгөний үйлчилгээнд дараах гүйлгээг хийнэ:
  - 3.4.1. Цахим мөнгө ашиглан бараа, ажил, үйлчилгээний төлбөр төлөх;
  - 3.4.2. Цахим мөнгийг бусад хэрэглэгчид шилжүүлэх;
  - 3.4.3. Цахим мөнгийг бэлэн мөнгөнд хөрвүүлэх;
  - 3.4.4. Бэлэн мөнгийг цахим мөнгөнд хөрвүүлэн дансанд хийх;
  - 3.4.5. Цахим мөнгөний дансны үлдэгдэл шалгах;
  - 3.4.6. Гүйлгээний хуулга авах;
  - 3.4.7. Зөвшөөрөл авсан бусад.
- 3.5. Үйлчилгээ эрхлэгчийн гаргасан, эргэлтэд байгаа нийт цахим мөнгө нь оролцогчоос цахим мөнгөнд хөрвүүлэхээр өгсөн бэлэн мөнгө, мөнгөн хөрөнгөөс илүүгүй байна.
- 3.6. Үйлчилгээ эрхлэгч нь цахим мөнгөний гүйлгээг бодит цагийн горимд, ажил амралтын өдөр хамаарахгүй 24 цагаар гүйцэтгэнэ.

- 3.7. Цахим мөнгө болон түүний баталгаа (баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгө)-г хадгаламж, татан төвлөрүүлсэн хөрөнгө гэж үзэхгүй, түүнд хүү, урамшуулал бодохгүй.
- 3.8. Цахим мөнгөөр зээл олгохгүй, цахим мөнгө нь зээлийн эх үүсвэр болохгүй.
- 3.9. Хэрэглэгч бүр нь цахим мөнгөний системд өөрийн гэсэн дахин давтагдахгүй дугаар эсвэл данстай байна.

#### ДӨРӨВ. ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

- 4.1. Үйлчилгээ эрхлэгч нь “Компанийн тухай” хуульд заасны дагуу үүсгэн байгуулсан Монгол Улсын хуулийн этгээд байна.
- 4.2. Үйлчилгээ эрхлэгч нь өөрийн гаргасан цахим мөнгөнөөс үүсэх бүх төлбөр тооцоог хариуцах бөгөөд оролцогчийн анхны шаардлагаар түүний цахим мөнгийг бэлэн мөнгө эсвэл мөнгөн хөрөнгөнд хөрвүүлж өгнө.
- 4.3. Үйлчилгээ эрхлэгч нь цахим мөнгө гаргах үйл ажиллагааны зөвшөөрлийг авснаас 6 сарын дотор тухайн цахим мөнгийг үйлчилгээнд гаргана.
- 4.4. Үйлчилгээ эрхлэгч нь “Үндэсний төлбөрийн системийн тухай” хуулийн 12.1-д заасан болон дараах шаардлагыг хангасан байна:
  - 4.4.1. Цахим мөнгө гаргах, үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг энэ журмын дагуу Монголбанкнаас авсан байх,
  - 4.4.2. Оролцогчийн цахим мөнгө болон мөнгөн хөрөнгийг аюулгүй, найдвартай хадгалах, хамгаалах систем, чадвартай байх;
  - 4.4.3. Цахим мөнгө гаргах, түүнийг бэлэн мөнгөнд хөрвүүлэх, гүйлгээ хийх болон төлбөр төлөх үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журамтай байх;
  - 4.4.4. Цахим мөнгөний гүйлгээнд гарах маргааныг цаг тухайд нь, оролцогчид хүндрэл учруулахгүйгээр шийдэх дүрэм, журамтай байх;
  - 4.4.5. Мэдээллийн технологийн болон банк, санхүүгийн боловсролтой, туршлагатай боловсон хүчинтэй байх;
  - 4.4.6. Эргэлтэд байгаа цахим мөнгөний мөнгөн хөрөнгийн баталгааг 100 хувь банк эсвэл Монголбанкинд байршуулах;
  - 4.4.7. Оролцогчийн холбогдох мэдээлэл, нэгж дансны болон нэгтгэсэн балансад шаардагдах нарийвчилсан, бүрэн мэдээллийг агуулах, хөтлөх боломж бүхий мэдээллийн системтэй байна. Тус систем нь цахим мөнгөний хөдөлгөөнийг хянах, оролцогчид болон цахим мөнгөний тоо хэмжээг тогтоох, цахим мөнгөний үйлчилгээнд оролцогчийн зөвшөөрсөн хэмжээнээс илүү гүйлгээ хийх, данс андуурсан зэрэг санамсаргүй үйлдэл, хулгайн болон сэжигтэй гүйлгээг илрүүлэх, гүйлгээг зогсоох, буцаах, түүнээс үүсэх маргааныг шийдвэрлэх чадвартай байх;
  - 4.4.8. Цахим мөнгөний систем нь хэрэгдэхэд хялбар, хямд, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн шаардлагыг хангасан байх;

- 4.4.9. “Төлбөрийн системд мөрдөх мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах, тус журмаар тавигдах шаардлагыг хангасан байх;
- 4.4.10. Нөхцөл байдлаас хамааран Монголбанкнаас тавих бусад шаардлагыг хангасан байх.
- 4.5. Үйлчилгээ эрхлэгч дараах эртэй:
- 4.5.1. Энэ журамд заасан шаардлагыг хангаж, холбогдох зөвшөөрлийг авсан үйлчилгээ эрхлэгч нь өөрийн нэрийн өмнөөс цахим мөнгө гаргаж, үйл ажиллагаанд ашиглаж болно;
- 4.5.2. Үйлчилгээ эрхлэгч нь энэ журмын 5 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан гэрээт төлөөлөгчөөр дамжуулан цахим мөнгөний үйлчилгээг хэрэглэгчид хүргэж болно;
- 4.5.3. Оролцогчийг хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, биелүүлээгүйгээс учирсан хохирлыг барагдуулахыг шаардах, хохирлыг арилгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 4.5.4. Оролцогчийн үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу явагдаж буй эсэхэд хяналт тавих, хууль тогтоомж, гэрээний шаардлагыг хангаагүй нөхцөлд гэрээг цуцлах санал гаргах;
- 4.5.5. Хууль хяналтын байгууллагаас оролцогчийн дансаар дамжин аливаа хууль бус гүйлгээ хийгдсэн тухай мэдэгдэл ирсэн тохиолдолд дансны зарлагын гүйлгээг зогсоох;
- 4.5.6. Оролцогчоос үйлчилгээний ерөнхий нөхцөл, гэрээнд заасан үйлчилгээний шимтгэл авах.
- 4.6. Үйлчилгээ эрхлэгч дараах үүрэгтэй:
- 4.6.1. Оролцогчтой гэрээ байгуулахын өмнө холбогдох хууль тогтоомж бусад эрх зүйн актад заасны дагуу тэдгээрийг таних (КҮС хийх), “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хууль болон холбогдох эрх зүйн актыг мөрдөж ажиллах;
- 4.6.2. Цахим мөнгөний системийн нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангасан байх, гүйлгээг тасралтгүй найдвартай дамжуулах;
- 4.6.3. Монголбанкнаас шаардсан мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгөх, хянан шалгагч, шалгалтын ажлын хэсгийг ажлын байр болон цахим мөнгөний системд чөлөөтэй нэвтрүүлэх;
- 4.6.4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх;
- 4.6.5. Оролцогчийн зөвшөөрөл, баталгаажуулалтгүйгээр цахим мөнгөний данснаас зарлагын гүйлгээ хийхгүй байх, хийгдсэн тохиолдолд учирсан хохирлыг хариуцах;
- 4.6.6. Оролцогчийг үйлчилгээний гарын авлагаар хангах;

- 4.6.7. Оролцогчийн болон гүйлгээний мэдээллийг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд зааснаас бусад зорилгоор ашиглахгүй байх, чандлан нууцлах;
  - 4.6.8. Цахим мөнгөний үйлчилгээний нууцлал, аюулгүй байдлыг хангаагүй буруутай үйлдлийн улмаас учирсан хохирлыг хариуцах;
  - 4.6.9. Оролцогч тус бүртэй үйлчилгээний нөхцөлийг ойлгомжтой заасан гэрээ байгуулах, түүнийг тайлбарлаж өгөх;
  - 4.6.10. Гэрээт төлөөлөгч, ЦМХА-тай хуанлийн 15 хоногийн дотор тооцоо нийлж тохируулах;
  - 4.6.11. Өөрийн гэрээт төлөөлөгчийн цахим мөнгөний үйлчилгээтэй холбоотой мэдээллийн технологийн нууцлал, аюулгүй байдал болон санхүүгийн хариуцлагыг бүрэн хариуцах, гэрээт төлөөлөгчөөр энэ журмын 5 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангуулах;
  - 4.6.12. Оролцогчид гүйлгээ амжилттай хийгдсэн эсэхийг тухай бүр мэдээлэх, энэ мэдээллийг үнэ төлбөргүй хүргэх сувагтай байх;
  - 4.6.13. Үйлчилгээ эрхлэгч нь оролцогчид лавлагаа, мэдээлэл өгөх, санал гомдол, маргаантай гүйлгээний мэдээллийг хүлээн авах байнгын утас, оператортой байх ба гомдол, санал, маргааныг цаг тухайд нь оролцогчдод хүндрэл учруулахгүйгээр барагдуулах;
  - 4.6.14. Шинээр бүртгүүлж байгаа оролцогчид ПИН кодыг нууцалж, битүүмжилсэн байдлаар хүлээлгэн өгөх;
  - 4.6.15. Хэрэглэгчийн нэвтрэх эрх, дансны мэдээлэл цахим халдлагад өртөж, алдагдсан тохиолдолд хэрэглэгчид нэн даруй мэдэгдэж, авч буй арга хэмжээ, үр дүнгийн талаар мэдээлэх;
  - 4.6.16. Шинээр гэрээт төлөөлөгч элсүүлэх бол энэ талаар ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө Монголбанкинд мэдэгдэж бүртгүүлэх;
  - 4.6.17. Шинээр элсэж байгаа гэрээт төлөөлөгч, ЦМХА-д холбогдох дүрэм, журмыг танилцуулж, мэдээлэл, гарын авлагаар хангах, шаардлагатай тохиолдолд сургалтанд хамруулах;
  - 4.6.18. Гэрээт төлөөлөгч болон ЦМХА болохыг нотолсон ажлын байрны батламж, нэгэн ижил таних тэмдэг бүхий хаягжилт хийх, коджуулах.
- 4.7. Үйлчилгээ эрхлэгч нь гэрээт төлөөлөгчтэй байгуулах гэрээнд дараах зүйлсийг заавал тусгана:
    - 4.7.1. Үйлчилгээ эрхлэгч, гэрээт төлөөлөгчийн эрх үүрэг, хариуцлага;
    - 4.7.2. Гэрээт төлөөлөгчийн хаяг, байршил;
    - 4.7.3. Тухайн цахим мөнгөний үйлчилгээг ашиглан хийж болох гүйлгээ, ашиглаж болох төхөөрөмж, хэрэгсэл, ашиглах арга, гүйлгээний үнийн дүнгийн болон давтамжийн хязгаарлалт;
    - 4.7.4. Үйлчилгээ эрхлэгч нь гэрээнд өөрчлөлт оруулах талаар оролцогчид хуанлийн 30 (гуч) хоногийн өмнө мэдэгдсэнээр гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах эрхтэй.

- Заасан хугацаанд карт эзэмшигч гэрээнээс татгалзаагүй бол, гэрээний өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцох тухай;
- 4.7.5. Цахим мөнгөний үйлчилгээнд нэвтрэх эрх, нууц үг, ПИН кодыг нууцлах тухай;
  - 4.7.6. Цахим мөнгөний үйлчилгээнд нэвтрэх эрх, нууц үг, ПИН кодыг хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан, өөрийн данснаас эрх олгогдоогүй гүйлгээ хийгдсэн болон бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн тохиолдолд үйлчилгээ эрхлэгчид нэн даруй мэдэгдэх тухай;
  - 4.7.7. Цахим мөнгөний гүйлгээнд үүсэх маргааныг хэрхэн зохицуулах, залруулгын гүйлгээг хэрхэн гүйцэтгэх тухай;
  - 4.7.8. Гомдол, маргаантай болон хулгайн гүйлгээний талаар мэдэгдэх хэлбэр, хугацаа, түүнд хариу өгөх, арга хэмжээ авах хугацаа;
  - 4.7.9. Үйлчилгээний шимтгэл, хураамжийн хэмжээ, түүнийг авах нөхцөл, хугацааны талаар мэдээлэл.
- 4.8. Үйлчилгээ эрхлэгч нь ЦМХА-тай байгуулах гэрээнд дараах зүйлсийг заавал тусгана:
- 4.8.1. Үйлчилгээ эрхлэгч, ЦМХА-ын эрх үүрэг, хариуцлага;
  - 4.8.2. ЦМХА-ын хаяг, байршил;
  - 4.8.3. Тухайн цахим мөнгийг бэлэн мөнгөний нэгэн адил тооцож ижил үнээр бараа, ажил, үйлчилгээний төлбөрт хүлээн авах, ямар нэгэн нэмэлт шимтгэл авахгүй байх талаар;
  - 4.8.4. Тухайн цахим мөнгөний үйлчилгээг ашиглан хийж болох гүйлгээний үнийн дүнгийн болон давтамжийн хязгаарлалт;
  - 4.8.5. Тухайн цахим мөнгийг зөвхөн бараа, ажил, үйлчилгээний төлбөр төлөх зорилгоор ашиглах тухай; (Жишээ нь: цахим мөнгөөр хөрөнгө оруулалт хийж болохгүй)
  - 4.8.6. Үйлчилгээ эрхлэгч нь гэрээнд өөрчлөлт оруулах талаар оролцогчид хуанлийн 30 (гуч) хоногийн өмнө мэдэгдсэнээр гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах эрхтэй. Заасан хугацаанд карт эзэмшигч гэрээнээс татгалзаагүй бол, гэрээний өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцох тухай;
  - 4.8.7. Цахим мөнгөний үйлчилгээнд нэвтрэх эрх, нууц үг, ПИН кодыг нууцлах тухай;
  - 4.8.8. Цахим мөнгөний үйлчилгээнд нэвтрэх эрх, нууц үг, ПИН кодыг хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан, өөрийн данснаас эрх олгогдоогүй гүйлгээ хийгдсэн болон бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн тохиолдолд үйлчилгээ эрхлэгчид нэн даруй мэдэгдэх тухай;
  - 4.8.9. Гомдол, маргаантай болон хулгайн гүйлгээний талаар мэдэгдэх хэлбэр, хугацаа, түүнд хариу өгөх, арга хэмжээ авах хугацаа;
  - 4.8.10. Үйлчилгээний шимтгэл, хураамжийн хэмжээ, түүнийг авах нөхцөл, хугацааны талаар мэдээлэл.
- 4.9. Үйлчилгээ эрхлэгч нь хэрэглэгчтэй байгуулах гэрээнд дараах зүйлсийг заавал тусгана:
- 4.9.1. Үйлчилгээ эрхлэгч, хэрэглэгчийн эрх үүрэг, хариуцлага;

- 4.9.2. Тухайн цахим мөнгөний үйлчилгээг ашиглан хийж болох гүйлгээ, ашиглаж болох төхөөрөмж, хэрэгсэл, ашиглах арга, гүйлгээний үнийн дүнгийн болон давтамжийн хязгаарлалт;
  - 4.9.3. Цахим мөнгөнд хөрвүүлсэн мөнгөн хөрөнгийг баталгааны дансанд байршуулах тухай;
  - 4.9.4. Үйлчилгээ эрхлэгч нь гэрээнд өөрчлөлт оруулах талаар оролцогчид хуанлийн 30 (гуч) хоногийн өмнө мэдэгдсэнээр гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах эрхтэй. Заасан хугацаанд карт эзэмшигч гэрээнээс татгалзаагүй бол, гэрээний өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцох тухай;
  - 4.9.5. Цахим мөнгөний үйлчилгээнд нэвтрэх эрх, нууц үг, ПИН кодыг нууцлах тухай;
  - 4.9.6. Цахим мөнгөний үйлчилгээнд нэвтрэх эрх, нууц үг, ПИН кодыг хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан, өөрийн данснаас эрх олгогдоогүй гүйлгээ хийгдсэн болон бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн тохиолдолд үйлчилгээ эрхлэгчид нэн даруй мэдэгдэх тухай;
  - 4.9.7. Гомдол, маргаантай болон хулгайн гүйлгээний талаар мэдэгдэх хэлбэр хугацаа, түүнд хариу өгөх, арга хэмжээ авах хугацаа;
  - 4.9.8. Үйлчилгээний шимтгэл, хураамжийн хэмжээ, түүнийг авах нөхцөл, хугацааны талаар мэдээлэл.
- 4.10. Үйлчилгээ эрхлэгч нь цахим мөнгөний системд дараах өөрчлөлт хийхээс 30 хоногийн өмнө тухайн өөрчлөлттэй холбоотой саналаа холбогдох Монголбанкинд танилцуулж, дүгнэлт гаргуулана:
- 4.10.1. Шинэ сувгуудыг ашиглан үйлчилгээний цар хүрээг тэлэх (интернет хандалт, ПОС төхөөрөмж гэх мэт);
  - 4.10.2. Технологийг бэлтгэн нийлүүлэгч болон цахим мөнгөний үйлчилгээг дамжуулан хүргэх үүрэн телефоны үйлчилгээ үзүүлэгч өөрчлөгдөх, нэмэгдэх;
  - 4.10.3. Үйлчилгээнд ашиглагдаж буй технологи, програм хангамж том хэмжээний өөрчлөлт, нэмэлт шинэчлэлт хийх.
- 4.11. Үйлчилгээ эрхлэгч нь цахим мөнгөний системд энэ журмын 4.10-т хамаарахгүй бусад өөрчлөлтийг хийсэн тухай бүр Монголбанкинд албан ёсоор мэдэгдэнэ.

#### ТАВ. ОРОЛЦОГЧ

- 5.1. Үйлчилгээ эрхлэгчийн нэрийн өмнөөс гэрээт төлөөлөгч нь дараах цахим мөнгөний үйлчилгээг үзүүлж болно:
- 5.1.1. Цахим мөнгийг нэг хэрэглэгчээс нөгөөд шилжүүлэх;
  - 5.1.2. Цахим мөнгийг бэлэн мөнгөнд хөрвүүлэх;
  - 5.1.3. Бэлэн мөнгийг цахим мөнгөнд хөрвүүлэх;
  - 5.1.4. Гүйлгээний хуулга гаргаж өгөх;
  - 5.1.5. Шинээр хэрэглэгч бүртгэх.

- 5.2. Хуулийн этгээд нь гэрээ байгуулж, шаардлага хангасан нөхцөлд хэд хэдэн үйлчилгээ эрхлэгчийн гэрээт төлөөлөгчөөр зэрэг ажиллаж болно.
- 5.3. Гэрээт төлөөлөгч, ЦМХА нь дараах эрхтэй:
  - 5.3.1. Гэрээ байгуулсны үндсэн дээр цахим мөнгөний үйлчилгээнд оролцох, цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс үзүүлж буй бусад үйлчилгээг авах;
  - 5.3.2. Өөрийн дансны үлдэгдэл болон гүйлгээний хуулгыг шаардлагатай үедээ үйлчилгээ эрхлэгчээс баталгаажуулан авах, үүнтэй холбоотой мэдээ, тайлбар авах;
  - 5.3.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг үйлчилгээ эрхлэгчээс шаардах.
- 5.4. ЦМХА нь дараах үүргийг хүлээнэ:
  - 5.4.1. Хэрэглэгчийн гомдол, саналыг хүлээн авч үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэх, шийдвэрлэх;
  - 5.4.2. Үйлчилгээ эрхлэгчид өөрт холбогдолтой мэдээллийг үнэн зөв, бүрэн өгөх;
  - 5.4.3. ПИН код, нууц кодоо үрэгдүүлсэн, хулгайд алдсан, өөрийн дансанд эрх олгогдоогүй гүйлгээ хийгдсэн тухай мэдсэн, өөрийн данстай холбоотой бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн болон өөрийн нууц код болон бусад кодыг эрх олгогдоогүй гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй тухай сэжиглэж байвал нэн даруй ПИН код, нууц кодоо солих, цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэх;
  - 5.4.4. Үйлчилгээ эрхлэгч болон хэрэглэгчийн төлбөр тооцоотой холбоотой аливаа мэдээ, мэдээллийн нууцыг чандлан сахих;
  - 5.4.5. Хаяг байршил болон үйл ажиллагааны талаарх холбогдох мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчид ажлын 5 өдрийн дотор мэдэгдэх.
- 5.5. Гэрээт төлөөлөгч дараах үүргийг хүлээнэ:
  - 5.5.1. Энэ журмын 5.4-д заасан үүрэг нэгэн адил хамаарна;
  - 5.5.2. Хэрэглэгч, ЦМХА-ын хүсэлтээр бэлэн мөнгийг цахим мөнгөнд хөрвүүлэх, цахим мөнгийг бэлэн мөнгөнд хөрвүүлэх болон бусад гүйлгээг хийх, ингэхдээ дансны дугаар, мөнгөн дүн, ПИН кодыг зөв оруулах, буруу оруулснаас үүсэх хохирлыг хариуцах;
  - 5.5.3. ПИН код, нууц кодоо үрэгдүүлсэн, хулгайд алдсан, өөрийн дансанд эрх олгогдоогүй гүйлгээ хийгдсэн тухай мэдсэн, өөрийн данстай холбоотой бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн болон өөрийн нууц код болон бусад кодыг эрх олгогдоогүй гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй тухай сэжиглэж байвал нэн даруй ПИН код, нууц кодоо солих, цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэх;
  - 5.5.4. Цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах бэлэн мөнгөний нөөц, түүний хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалтай холбогдон үүсэх асуудлыг бүрэн хариуцах;
  - 5.5.5. Үйлчилгээ үзүүлж байгаа байрандаа үйлчилгээ эрхлэгчээс олгосон таних тэмдэг бүхий батламж, дансны дугаар, үйлчилгээний үнийн саналыг харилцагчдад харагдахуйц ил газар байрлуулах;
  - 5.5.6. Гүйлгээний баримтыг гүйлгээ тутамд үйлдэн бүртгэх, баримтыг нэг жилээс доошгүй



- хугацаанд архивлан хадгалах;
- 5.5.7. Шинэ хэрэглэгчийн бүртгэлийг үнэн зөв, түргэн шуурхай гүйцэтгэх;
- 5.5.8. Үйлчилгээ эрхлэгчээс баталж гаргасан журмын дагуу цахим мөнгөний дансандаа заавал байлгах мөнгөн дүнг байршуулсан байна.
- 5.6. Хэрэглэгч нь дараах эрхтэй:
- 5.6.1. Гэрээний үндсэн дээр цахим мөнгөний үйлчилгээ авах;
- 5.6.2. Үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааны журамтай танилцах;
- 5.6.3. Өөрт холбогдох дансны хуулга болон бусад мэдээллийг гаргуулах;
- 5.6.4. Цахим мөнгөний үйлчилгээний эрхээ түр хаалгах, сэргээлгэх, цуцлах;
- 5.6.5. Цахим мөнгөний үйлчилгээний талаар гомдол, гүйлгээний талаар марган гаргах, түүнийг гэрээнд заасан хугацаанд шийдүүлэх;
- 5.6.6. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс шаардах.
- 5.7. Хэрэглэгч нь дараах үүргийг:
- 5.7.1. Үйлчилгээ эрхлэгчид өөрт холбогдолтой мэдээллийг үнэн зөв, бүрэн өгөх;
- 5.7.2. ПИН код, нууц кодоо үрэгдүүлсэн, хулгайд алдсан, өөрийн дансанд эрх олгогдоогүй гүйлгээ хийгдсэн тухай мэдсэн, өөрийн данстай холбоотой бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн болон өөрийн нууц код болон бусад кодыг эрх олгогдоогүй гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй тухай сэжиглэж байвал нэн даруй ПИН код, нууц кодоо солих, цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэх;
- 5.7.3. Хэрэглэгч нь өөрийн цахим мөнгөний дансаа удирдахад ашиглагдах хэрэглэгчийн нэр, нууц код, ПИН код болон бусад мэдээллийн нууцлалыг хадгалах, өөрийн буруутай үйл ажиллагаанаас дансны дугаар, үнийн дүнг буруу оруулсан тохиолдолд хариуцлагыг өөрөө хүлээх.

#### ЗУРГАА. ЦАХИМ МӨНГӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯЗГААРЛАЛТ, ЭРСДЭЛ

- 6.1. Гэрээт хамтрагч болон ЦМХА-ын нэг удаад хийх гүйлгээний дээд хэмжээ 1,000,000.0 (нэг сая) төгрөг, нэг өдөрт хийх гүйлгээний дээд хязгаар 5,000,000.0 (таван сая) төгрөг байна.
- 6.2. Хэрэглэгчийн нэг удаад хийх гүйлгээний дээд хэмжээ 1,000,000.0 (нэг сая) төгрөг, нэг өдөрт хийх гүйлгээний дээд хязгаар 3,000,000.0 (гурван сая) төгрөг байна.
- 6.3. Нэг хэрэглэгчийн дансан дахь цахим мөнгөний хэмжээ 50,000,000.0 (тавин сая) төгрөгөөс хэтрэхгүй байна.
- 6.4. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь гүйлгээ хийх, хийгдсэн гүйлгээнд залруулга хийхэд давхар хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байна. Гүйлгээ хийх эрх бүхий ажилтан болон удирдах ажилтныг “мэргэжлийн хариуцлагын даатгал”-д хамруулна.
- 6.5. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь цахим хэтэвч эзэмшигч, гүйлгээ хариуцсан ажилтны санамсар болгоомжгүй байдлаас үүдэн хийгдсэн буруу гүйлгээг шуурхай залруулах, үүсэх хор хохирлоос сэргийлэх, багасгахад чиглэсэн арга хэмжээг журмаар

зохицуулна.

## ДОЛОО. ЦАХИМ МӨНГӨ ГАРГАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

- 7.1. Цахим мөнгө гаргах үйл ажиллагааны зөвшөөрөл хүсэгч нь “Үндэсний төлбөрийн системийн тухай” хуулийн 11.1-д заасан баримт бичиг болон дараах баримт бичгийн эх хувийг эсвэл баталгаажуулсан хувийг бүрдүүлж Монголбанкинд ирүүлнэ.
  - 7.1.1. Цахим мөнгө гаргах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хүсэлт;
  - 7.1.2. Энэ журмын 4 дүгээр бүлэгт заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичиг;
  - 7.1.3. Оролцогчтой байгуулах гэрээний загвар;
  - 7.1.4. Цахим мөнгөний системийн тайлбар;
  - 7.1.5. Техник тоног төхөөрөмж, програм хангамжийн тодорхойлолт (Тодорхойлолтод техник тоног төхөөрөмж, програм хангамжийн гарал үүсэл, загвар, техникийн үзүүлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл байна);
  - 7.1.6. Оролцогч болон гүйлгээний мэдээллийг хадгалах мэдээллийн бааз үүсгэх тухай журам, заавар;
  - 7.1.7. Цахим мөнгөний бүх төрлийн гүйлгээ хэрхэн хийгдэх шат дараалал болон мөнгөн хөрөнгө, мэдээллийн урсгалын схемийг агуулсан үйл ажиллагааны журам;
  - 7.1.8. Дотоод хяналтын журам;
  - 7.1.9. Мэдээллийн технологийн нууцлал, аюулгүй байдлын журам;
  - 7.1.10. Эрсдлийн удирдлагын баримт бичиг;
  - 7.1.11. Үйл ажиллагааны тасралтгүй найдвартай байдлын журам (мэдээллийн технологийн нөөц төвийн тухай мэдээллийг агуулсан байх), түүнийг хангах, турших Онцгой байдлын төлөвлөгөө;
  - 7.1.12. Цахим мөнгөний үйл ажиллагааг хариуцах нэгжийг тодорхойлсон зураглал, ажлын байрны дэлгэрэнгүй тодорхойлолт;
  - 7.1.13. Цахим мөнгө гаргах үйл ажиллагааны зөвшөөрлийн хураамжийг “Монголбанкны үйлчилгээний шимтгэл, хураамжийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу төлсөн баримт;
  - 7.1.14. Нөхцөл байдлаас шалтгаалан Монголбанкнаас шаардсан бусад баримт бичиг.
- 7.2. Монголбанкны нь хүсэлт гаргагчаас бүрэн гүйцэд ирүүлсэн баримт бичгийг хүлээж авснаас хойш холбогдох зөвшөөрөл олгох эсэх асуудлыг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.
- 7.3. Монголбанк нь үйл ажиллагаанд мөрдөх бодлогын болон эрх зүйн баримт бичиг, оролцогчтой байгуулах гэрээний төслийг хянаж, тухайн үйл ажиллагаатай холбогдон гарах эрсдэлүүдийг бууруулах, хянах бололцоотой эсэх байдалд дүгнэлт гаргана.
- 7.4. Цахим мөнгөний үйлчилгээ, ирүүлсэн баримт материал нь холбогдох хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актаар тавьсан шаардлагад нийцээгүй бол Монголбанк нь цахим мөнгө гаргах үйл ажиллагааны зөвшөөрлийг олгохоос татгалзана.

- 7.5. Цахим мөнгө гаргах үйл ажиллагааны зөвшөөрөл олгох эсэх шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгч гаргана. Монголбанкнаас зөвшөөрөл олгосон эсэх талаарх хариуг шийдвэр гарснаас хойш хүсэлт гаргагчид ажлын 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.
- 7.6. Цахим мөнгөний үйл ажиллагаа эрхлэгч нь зөвшөөрөл авахад бүрдүүлсэн журам, заавар, бичиг баримт, гэрээ, техник технологи, програм хангамжид системд нөлөөлөхүйц өөрчлөлт оруулах тохиолдолд өөрчлөлтийн тухай мэдээллийг тухай бүрт нь ирүүлнэ.
- 7.7. Цахим мөнгө гаргах үйл ажиллагааны зөвшөөрлийг эхний удаад 4 жилээр өгч, хугацаагүй сунгана.
- 7.8. Монголбанк нь “Үндэсний төлбөрийн системийн тухай” хуулийн 19 дүгээр зүйлд заасан болон дараах үндэслэлээр цахим мөнгө гаргах үйл ажиллагааны зөвшөөрлийг түдгэлзүүлэх буюу хүчингүй болгоно:
  - 7.8.1. Оролцогчийн гүйлгээ, төлбөр тооцоог гүйцэтгээгүй, удаа дараа саатуулсан, буруу гүйцэтгэсэн нь тогтоогдсон, эрх ашгийг ноцтой зөрчсөн;
  - 7.8.2. Үйл ажиллагааны техникийн нууцлал, аюулгүй байдал, тасралтгүй, найдвартай ажиллагааг зохих түвшинд хангаагүй нь тогтоогдсон;
  - 7.8.3. Үзүүлж байгаа цахим мөнгөний үйлчилгээ нь төлбөрийн системийн аюулгүй найдвартай байдал, санхүүгийн тогтвортой байдал сөргөөр нөлөөлсөн, нөлөөлөх нь тогтоогдсон;
  - 7.8.4. Үйлчилгээ эрхлэгч нь энэ журмын энэ журамд заасан шаардлагыг өөрийн хамтран ажиллаж байгаа гэрээт төлөөлөгч, ЦМХА-аар хангуулаагүй нь тогтоогдсон;
  - 7.8.5. Монголбанкнаас тавьсан шаардлагыг удаа дараа зөрчсөн, биелүүлээгүй;
  - 7.8.6. Цахим мөнгөний үйлчилгээг эрхлэгч нь 6 сарын турш үйл ажиллагаа явуулаагүй;
  - 7.8.7. Хуурамч баримт бичиг бүрдүүлэн зөвшөөрөл авсан нь тогтоогдсон;
  - 7.8.8. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

#### НАЙМ. ЦАХИМ МӨНГӨНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

- 8.1. Үйлчилгээ эрхлэгч нь цахим мөнгөний төлбөр тооцооны үнэн зөв байдал, тоо баримт ба өгөгдлийн баталгаатай байдлыг бүрэн хариуцна.
- 8.2. Үйлчилгээ эрхлэгчийн цахим мөнгөний систем, түүний нууцлалын түвшинд Монголбанк шалгалт хийнэ.
- 8.3. Дээр дурдсан шалгалтын үр дүнг Монголбанкнаас шаардлагатай гэж үзвэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж болно.
- 8.4. Цахим мөнгөний үйлчилгээнд оролцогч байгууллага, иргэд харилцагчаас төлбөр, гүйлгээ, үйлчилгээний талаар санал, хүсэлт, гомдлыг Монголбанкинд гаргаж болно.
- 8.5. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь тухайн долоо хоногийн гүйлгээнд гарсан байгаа нийт цахим мөнгөний хэмжээ, цахим мөнгөний шилжүүлгийн тоо, дүн, маргаан гарсан гүйлгээний тоо, дүн, баталгааны дансанд байгаа мөнгөн хөрөнгийн хэмжээг өдөр тутмаар гаргаж дараагийн долоо хоногийн Лхагва гаригт багтаан Монголбанкинд ирүүлнэ.

- 8.6. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь баталгааны дансны сар бүрийн хуулгыг тухайн банкаар баталгаажуулж дараа сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ.

#### ЕС. БАТАЛГААНЫ ДАНС

- 9.1. Оролцогчийн цахим мөнгөнд хөрвүүлсэн мөнгөн хөрөнгийг үйлчилгээ эрхлэгч нь баталгааны дансанд хадгалах бөгөөд үйлчилгээ эрхлэгч нь дампуурсан тохиолдолд баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгийг зөвхөн оролцогчийн цахим мөнгийг бэлэнжүүлж, хохирлыг барагдуулах зорилгоор ашиглана.
- 9.2. Үйлчилгээ эрхлэгч нь Баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгийг оролцогчийн өмнөөс энэ журамд заасны дагуу захиран зарцуулах ба энэ тухай оролцогчтой байгуулах гэрээнд тусгана.
- 9.3. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгө нь эргэлтэд гаргасан нийт цахим мөнгөнөөс бага байвал дутууг 1 хоногийн дотор нөхнө.
- 9.4. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь батлагааны дансан дахь мөнгөн хөрөнгийг зөвхөн оролцогчийн цахим мөнгийг бэлэнжүүлэх зорилгоор ашиглана. Баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгийг өөр зорилгоор ашиглах, барьцаа болгохыг хориглоно.

#### АРАВ. ХАРИУЦЛАГА

- 10.1. Энэ журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол буруутай этгээдэд Монголбанкнаас дараах арга хэмжээг авна.
- 10.1.1. Цахим мөнгөний үйл ажиллагааг холбогдох журам, заавар, гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй бол холбогдох этгээдэд Банкны тухай, Үндэсний төлбөрийн системийн тухай болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 10.1.2. Энэхүү журмыг хэрэгжүүлэх талаар Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийг биелүүлээгүй ажилтан, албан тушаалтныг холбогдох хууль тогтоомж болон Зөрчлийн тухай хуульд заасны дагуу торгох хүртэл хариуцлага хүлээлгэнэ.